



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын нэр: “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох”

Аудитын код: ХЭА-2024/11-22-ШТА-НА

Чингис хот 2024 он

Аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор
Ж.Ганбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Энх-Амгалан

Утас: 91119424 Цахим хаяг: enkh-amgalang@audit.gov.mn

Аудитор Б.Ариунаа

Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn

ГАРЧИГ

1. Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
2. Бүлэг 1. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтооход харгалзан үзэх сонгогчийн тоо, өрхийн тоог холбогдох төрийн байгууллагуудаас гаргуулан авсан.	6
1.1 Нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлын дээд хэмжээг тогтооход харгалзан үзэх өрхийн тоог 2024 оны 6 дугаар сарын 13-ны байдлаар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс гаргасан байна.	6
1.2 Өрхийн тоо, сонгогчийн тоог харгалзан сонгуулийн зардлын тооцоолол хийх аргачлалыг баталсан байна.	6
3. Бүлэг 2. Сонгуулийн тойргийн тоо, нутаг дэвсгэрийн байршил, сонгууль явуулах өдрийг тогтоох тухай шийдвэр гаргасан байна.	6
2.1 Орон нутгийн сонгуулийн тойргийн тоо, нутаг дэвсгэр, тойрогт ноогдох мандатын тоог аймаг, сумаар баталсан байна.	6
2.2 Орон нутгийн сонгуулийн сурталчилгааг эхлүүлэх, зогсоох өдрийг тодорхой тогтоосон байна.	7
4. Бүлэг 3. Радио, телевиз, цахим хуудас ашиглан явуулах сурталчилгаа болон бүх төрлийн хэвлэмэл хуудас хэвлүүлэх зардлын зах зээлийн үнийн мэдээллийн баталгаат эх сурвалжийг үндэслэн тогтоосон.	7
3.1 Радио, телевиз ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах хугацааг хуулиар тогтоосон боловч үнэ тарифын мэдээлэл хангалтгүй байна.	7
3.2 Орон нутгийн сонгуульд цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах хугацаа байгаа ч үнэ тарифын баталгаат эх сурвалж хангалтгүй байна.	7
3.3 Бүх төрлийн хэвлэмэл хуудас, сонин, сэтгүүл ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах давтамж, хэмжээ нь тодорхой байгаа боловч орон нутгийн сонгуулийн хувьд орон нутагт хэвлэлийн байгууллага цөөхөн, үнэ тариф өндөр байгаа нь зардлын дээд хэмжээг буруулахад нөлөөлөхгүй байна.	8
5. Бүлэг 4. Сонгуулийн сурталчилгааны ажлыг эрхлэн явуулах сонгууль эрхэлсэн байгууллагын үйл ажиллагааны зардал, тээврийн хэрэгслийн болон бусад төрлийн зардлыг хуульд заасны дагуу төлөвлөсөн.	8
4.1 Сонгуулийн сурталчилгааны ажлыг эрхлэн явуулах сонгууль эрхэлсэн байгууллагын зарцуулах зардлыг бүрэн тодорхойлсон байна.	8
4.2 Сонгуулийн сурталчилгааны тээврийн хэрэгслийн болон бусад төрлийн зардлыг тооцоолоход шаардагдах мэдээ мэдээлэл бүрэн байна.	9
6. Дүгнэлт:	10

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АСХ	Аймгийн сонгуулийн хороо
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СХ	Сонгуулийн хороо
ТББ	Төрийн бус байгууллага
УБГ	Улсын бүртгэлийн хэлтэс
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХК	Хувьцаат компани
ХМХ	Хэвлэл мэдээллийн хэрэгсэл

1 Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь заалт, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 06 дугаар тогтоол, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2023 оны 08 дугаар тогтоол, Төрийн аудитын байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг үндэслэн аудитыг гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтыг дэвшүүлэн аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, нийтэд мэдээлэх;
- Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоож, нийтэд мэдээлэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээ, сонгуулийн тойрог, хэсгийн байршил, өрхийн болон сонгогчийн тоо зэрэг эрх бүхий байгууллагаас гаргасан судалгаа, мэдээлэл мөн хуулиар зөвшөөрсөн сонгуулийн сурталчилгаанд зарцуулах холбогдох зардлын мэдээлэл, үнэ тариф зэрэг шаардлагатай эх сурвалжийг ашиглав.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, холбогдох эрх зүйн актад заасан орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох, нийтэд мэдээлэхтэй холбоотой АСХ, УБХ, СХ, улс төрийн намууд болон холбогдох бусад байгууллагуудыг хамруулсан.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУС 100-400, 4000, МУ-ын төрийн аудитын стандарт MNS6817-6:2020, MNS6817-8:2020 Нийцлийн аудитын зарчим, МУЕА-ын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан “Аудит хийх журам”, 2021 оны А/71 дүгээр тушаалаар баталсан “Нийцлийн аудит хийх журам”-ын дагуу гүйцэтгэж, хэвлэл мэдээлэл, радио, телевиз, цахим үйлчилгээ үзүүлдэг иргэн, аж ахуйн нэгж, орон нутаг дахь улс төрийн нам, эвслээс үнийн санал авч, зарим төрийн байгууллагаас шаардлагатай мэдээллийг цуглуулж орон нутгийн сонгуулийн тойрогт нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах дээд хэмжээг тогтоолоо.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг газрын дарга, Тэргүүлэх аудитор Ж.Ганбаатар хянан удирдаж, аудитын менежер Д.Оюунтуяа үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Энх-Амгалан, аудитор Б.Ариунаа нар 2024 оны 6 дугаар сарын 02-ноос 27-ны өдрүүдэд хийж гүйцэтгэсэн.

**Хүндрэл
бэрхшээл**

Орон нутагт хэвлэл мэдээлэл, радио, телевиз, цахим сүлжээний үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуй нэгж ховор, үнэ өндөр байгаагаас сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтооход хүндрэлтэй байлаа.

**БҮЛЭГ 1. НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ ТОГТООХОД
ХАРГАЛЗАН ҮЗЭХ СОНГОГЧИЙН ТОО, ӨРХИЙН ТООГ ХОЛБОГДОХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДААС
ГАРГУУЛАН АВСАН.**

**1.1 НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧИЙН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ ТОГТООХОД
ХАРГАЛЗАН ҮЗЭХ ӨРХИЙН ТООГ 2024 ОНЫ 6 ДУГААР САРЫН 13-НЫ БАЙДЛААР АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС ГАРГАСАН БАЙНА.**

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 2024 оны 6 дугаар сарын 11-ний 477 албан тоот хүргүүлснээр, тус байгууллагаас аймгийн хэмжээнд сонгуулийн насны 51,564 иргэн бүртгэлтэй байгаа мэдээллийг 6 дугаар сарын 13-ны байдлаар сум, тосгон, багаар гарган 1/373 албан тоотоор ирүүлсэн.

Аймгийн Статистикийн хэлтэст 2024 оны 6 дугаар сарын 19-ний 501 албан тоот хүргүүлснийг мөн өдрийн 52 тоот албан тоотоор аймгийн хэмжээнд 25,856 өрх бүртгэлтэй байгаа мэдээллийг ирүүлсэн байна.

**1.2 ӨРХИЙН ТОО, СОНГОГЧИЙН ТООГ ХАРГАЛЗАН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООЛОЛ ХИЙХ
АРГАЧЛАЛЫГ БАТАЛСАН БАЙНА.**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлд сонгуулийн сурталчилгааг хуульчилсан ба уг сурталчилгаанд зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох тухай мөн хуулийн 49 дүгээр зүйлд заасан байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны 2024 оны 6 дугаар тогтоолоор “Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлал”-ыг баталсан байна.

ҮАГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газраас гаргасан “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль”-ийн хүрээнд Төрийн аудитын газруудын дүгнэлт гаргах, аудит хийхэд баримтлах бодлого, арга зүйн асуудал, СНАГ-ын 2024.05.29-ний “Чиглэл хүргүүлэх тухай” 07/19 тоот албан бичгийг үндэслэн СЕХ-оос баталсан 6 дугаар тогтоолыг баримтлан зардлын дээд хэмжээг тогтоолоо.

**БҮЛЭГ 2. СОНГУУЛИЙН ТОЙРГИЙН ТОО, НУТАГ ДЭВСГЭРИЙН БАЙРШИЛ, СОНГУУЛЬ ЯВУУЛАХ
ӨДРИЙГ ТОГТООХ ТУХАЙ ШИЙДВЭР ГАРГАСАН БАЙНА.**

**2.1 ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН ТОЙРГИЙН ТОО, НУТАГ ДЭВСГЭР, ТОЙРОГТ НООГДОХ
МАНДАТЫН ТООГ АЙМАГ, СУМААР БАТАЛСАН БАЙНА.**

Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 07 дугаар тогтоолоор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрог 26, мандатын тоог 35 байхаар баталжээ.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тойрог 92, мандатын тоо 384 байхаар сум тус бүрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан байна.

МУИХ-ын 2024 оны 19 дүгээр тогтоолоор “Аймаг, нийслэл, сум, дүүгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” баталсан байна.

2.2 ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААГ ЭХЛҮҮЛЭХ, ЗОГСООХ ӨДРИЙГ ТОДОРХОЙ ТОГТООСОН БАЙНА.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д “Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00:00 цагаас өмнө зогсооно.” гэж хуульчилсныг үндэслэн сурталчилгаа хийх хоногийн тоог 17 хоногоор тооцов.

БҮЛЭГ 3. РАДИО, ТЕЛЕВИЗ, ЦАХИМ ХУУДАС АШИГЛАН ЯВУУЛАХ СУРТАЛЧИЛГАА БОЛОН БҮХ ТӨРЛИЙН ХЭВЛЭМЭЛ ХУУДАС ХЭВЛҮҮЛЭХ ЗАРДЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН МЭДЭЭЛЛИЙН БАТАЛГААТ ЭХ СУРВАЛЖИЙГ ҮНДЭСЛЭН ТОГТООСОН.

3.1 РАДИО, ТЕЛЕВИЗ АШИГЛАН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ ХУГАЦААГ ХУУЛИАР ТОГТООСОН БОЛОВЧ ҮНЭ ТАРИФЫН МЭДЭЭЛЭЛ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.6, 45 дугаар зүйлийг үндэслэн СЕХ-ын 2024 оны 6 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их хурлын ээлжит сонгуульд нам, эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлал”-ын 3 дугаар бүлгийн 3.6-д “Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардал”-ын шалгуур, аргачлалыг ашиглав.

Харилцаа холбооны зохицуулах хорооноос ирүүлсэн Телевиз, радиогийн тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллээр тус аймагт орон нутгийн 1 телевиз буюу Өндөрхаан телевиз үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус телевизээс авсан үнийн саналаар телевизийн нэвтрүүлгийн үнийг тогтоох боломжгүй учраас ҮАГ-аас авсан үнийн саналын дунджаар радио, телевиз ашиглах зардлыг дараах байдлаар тооцлоо. Зөвшөөрөлтэй радио байхгүй байна.

*Телевизээр нэвтрүүлэг хийх зардал=(нэвтрүүлэх дундаж үнэ*нэвтрүүлгийн 15 минут*телевизийн тоо*сонгуулийн сурталчилгааны дундаж хоног)/нийт мандатын тоо*

Радиоогоор сурталчилгаа хийх зардал=(нэвтрүүлэх дундаж үнэ нэвтрүүлгийн нэг удаагийн хугацаа*радиогийн тоо*сонгуулийн сурталчилгааны хоног)/мандатын тоо*

3.2 ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД ЦАХИМ ОРЧИН АШИГЛАН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА ЯВУУЛАХ ХУГАЦАА БАЙГАА Ч ҮНЭ ТАРИФЫН БАТАЛГААТ ЭХ СУРВАЛЖ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.

Орон нутагт идэвхтэй цахим хуудас эзэмшиж ашигладаг Хорин хоёр нь юс ХМХ, Амжилтын ташуур ТББ, Зүрхэн нутгийн дуу хоолой холбоо ТТБ-д үнийн санал авахаар албан тоот хүргүүлсэн боловч Зүрхэн нутгийн дуу хоолой ТББ буюу ARUUKHAN.MN сайтаас ирүүлсэн үнэ тариф нь цахим хуудасны зардал тооцох үзүүлэлттэй нийцэхгүй байсан. Иймд орон нутгийн улс төрийн намуудын ирүүлсэн үнийн саналын дундаж үнийг баримтлан тогтоов.

Цахим хуудасны зардал=домайн нэр үүсгэх зардал+хост хийх зардал

Бусад цахим хуудасны зардал=Баннер байршуулах зардал*вебсайтын тоо*
сонгуулийн сурталчилгааны хоног

*3.3 БҮХ ТӨРЛИЙН ХЭВЛЭМЭЛ ХУУДАС, СОНИН, СЭТГҮҮЛ АШИГЛАН СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА
ЯВУУЛАХ ДАВТАМЖ, ХЭМЖЭЭ НЬ ТОДОРХОЙ БАЙГАА БОЛОВЧ ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙН
ХУВЬД ОРОН НУТАГТ ХЭВЛЭЛИЙН БАЙГУУЛЛАГА ЦӨӨХӨН, ҮНЭ ТАРИФ ӨНДӨР БАЙГАА НЬ
ЗАРДЛЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ БУРУУЛАХАД НӨЛӨӨЛӨХГҮЙ БАЙНА.*

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн
тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.1, 40 дүгээр зүйлийг үндэслэн СЕХ-ын 2024 оны
6 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их хурлын ээлжит сонгуульд нам,
эвсэл болон нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг тогтоох аргачлал”-ын 3
дугаар бүлгийн 3.1-д “Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх, сонгогчдод
тараах зардал”-ын шалгуур, аргачлалыг ашиглав.

Хэвлэмэл материал хэвлүүлэх зардлыг зөвхөн аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн
нэр дэвшигчээс зарцуулахаар тооцсон.

Үүнд: Сонин, сэтгүүл, ухуулах хуудас буюу зурагт хуудас хэвлүүлэх зардал
орлоо.

-Сонин хэвлүүлэх зардал=Хэвлэлийн дундаж үнэ*тухайн хэсгийн өрхийн тоо

-Сэтгүүл хэвлүүлэх зардал=Хэвлэлийн дундаж үнэ*тухайн хэсгийн өрхийн тоо

-Ухуулах хуудас буюу зурагт хуудас=Зурагт хуудас хамгийн их солих боломж*ухуулах буюу
зурагт хуудасны тоо* хэвлэлийн дундаж үнэ*нэгдсэн самбарын тоо

Хэвлэмэл материалын дундаж үнийг орон нутаг дахь 3 намаас авсан үнийн
саналын дундаж үнээр тооцсон.

2.Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг тараах зардлыг Аймаг,
нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 40
дүгээр зүйлийн 40.9-д “Сурталчилгааны хэвлэмэл материалыг шуудангаар хүргүүлж
болно.” гэснийг үндэслэн “Монгол шуудан ХК”-ны Хэнтий аймгийн Шуудан
үйлчилгээний газрын хүргэлтийн үнэ тарифыг үндэслэн тооцсон.

Шуудан хүргэлтийн зардал=Илгээлтийн үнэ*хэмжээ

**БҮЛЭГ 4. СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫГ ЭРХЛЭН ЯВУУЛАХ СОНГУУЛЬ ЭРХЭЛСЭН
БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ, ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БОЛОН БУСАД ТӨРЛИЙН
ЗАРДЛЫГ ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ ТӨЛӨВЛӨСӨН.**

**4.1 СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ АЖЛЫГ ЭРХЛЭН ЯВУУЛАХ СОНГУУЛЬ ЭРХЭЛСЭН
БАЙГУУЛЛАГЫН ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫГ БҮРЭН ТОДОРХОЙЛСОН БАЙНА.**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн
тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.2-т заасан “Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд
сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах”, 41.1-д “Сонгуулийн
сурталчилгаанд зурагт самбар, дэлгэц ашиглаж болно. Зурагт самбар, дэлгэц нь нэг
хэсэгт 10-аас илүүгүй байна.”, 41.2-т “Зурагт самбар, дэлгэц нь хоёр хэвлэлийн

хуудаснаас илүүгүй хэмжээтэй, хөдөлгөөнт хэлбэртэй байж болох бөгөөд хэлбэр, загварт хязгаарлалт тавихгүй.” гэснийг тус тус үндэслэн нийтийн эзэмшлийн гудамж талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах зардлыг улс төрийн намаас авсан үнийн саналын өндөр үнээр зөвхөн аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн тойрогт нам, эвслээс зарцуулахаар тооцоолсон. Үүнд:

*Зурагт самбарын зардал=Хэвлэлийн өндөр үнэ*Хэвлэлийн хэмжээ/м2/*самбарын тоо*

4.2 СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГААНЫ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БОЛОН БУСАД ТӨРЛИЙН ЗАРДЛЫГ ТООЦООЛОХОД ШААРДАГДАХ МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ БҮРЭН БАЙНА.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2.5-д заасан “ухуулах байр ажиллуулах” зардлыг зөвхөн аймаг, сумын ИТХ-ын сонгуульд нэр дэвшигчээс зарцуулахаар тооцоолсон Үүнд: ухуулах байрны түрээсийн зардал, ухуулагчийн урамшууллын зардал, тээврийн хэрэгслийн зардал зэрэг багтсан.

*Ухуулах байрны түрээсийн зардал=хэсгийн хорооны ухуулах байрны тоо*байрны түрээсийн дундаж үнэ* сонгуулийн сурталчилгааны хоног*

*Ухуулагчийн урамшууллын зардал=тухай хэсгийн хорооны ухуулагчийн тоо*хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ*0.5*

*Тээврийн хэрэгслийн зардал=шатахууны дундаж үнэ*өдөрт зарцуулах шатахууны хэмжээ*сонгуулийн хоног*

ДҮГНЭЛТ:

Аймгийн ИТХ-ын сонгуулийн тойрогт нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг **364.3 сая төгрөгөөр** тогтоосон. Үүнийг зардлаар нь харуулбал:

- Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбарын зардлын дүн: **36.8 сая төгрөг**

- Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардлын дүн: **39.6 сая төгрөг**

- Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардлын дүн: **208.5 сая төгрөг**

- Цахим орчин ашиглах зардлын дүн: **79.4 сая төгрөг**

Аймгийн ИТХ-ын сонгуулийн тойрогт нэг нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг 23 сум, тосгоны 26 тойрогт **32.7-84.9 сая төгрөгөөр** тогтоосон байна. Үүнийг зардлаар харуулбал:

- Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материал хэвлүүлэх зардлын дүн: **109.5 сая төгрөг**

- Сонгуулийн сурталчилгааны хэвлэмэл материалыг тараах зардлын дүн: **181.3 сая төгрөг**

- Намын далбааг гудамж талбайд байршуулах, таних тэмдэг, уриа ашиглах зардлын дүн: **21.0 сая төгрөг**

- Ухуулах байр ажиллуулах зардлын дүн: **300.3 сая төгрөг**

- Сонгуулийн сурталчилгаанд радио, телевиз ашиглах зардлын дүн: **530.4 сая төгрөг**

- Цахим орчин ашиглах зардлын дүн: **175.0 сая төгрөг**

Сумын ИТХ-ын сонгуулийн тойрогт нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг **26.0-31.3 сая төгрөгөөр**, нэг нэр дэвшигчээс зарцуулах зардлын дээд хэмжээг **12.4-37.6 сая төгрөгөөр** тогтоолоо.